



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/550

Мандалговь

Тэгш дүүрэн хөтөлбөрийн хороог  
шинэчлэн байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 216 тоот тушаалын зургаадугаар хавсралтын 3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг хамт олонд тулгуурлан дээшлүүлж, тэдний бие дааж амьдрахад дэмжлэг үзүүлж, амьдралын чанарт ахиц гаргах зорилго бүхий "Тэгш дүүрэн" хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Хорооны дарга: Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн

Зээлийн эргэлтийн сан хариуцсан гишүүн:

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Малын эргэлтийн сан хариуцсан гишүүн бөгөөд нарийн бичгийн дарга:

Аймгийн ЗДТГ-ын Эрүүл мэндийн асуудал хариуцсан

мэргэжилтэн

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийгмийн бүхий л салбарын үйлчилгээ, гэр бүл хамт олны оролцоог сайжруулж ажиллахыг "Тэгш дүүрэн" хөтөлбөрийн хороонд үүрэг болгосугай.

Гурав. "Тэгш дүүрэн" хөтөлбөрийн зээлийн эргэлтийн сан болон малын эргэлтийн санд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хамтын бүлгийг удирдлага чиглэлээр тогтмол хангаж, хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/90 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

0200929

